



## НИЙСЛЭЛИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

Албан хаагчийн 2023 оны жилийн эцсийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний баг ажиллуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, Засгийн газрын 2023 оны "Журам шинэчлэн батлах тухай" 301 дүгээр тогтоол, 2019 оны "Журам батлах тухай" 5 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны "Аргачлал, загвар батлах тухай" 98 дугаар тушаал, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/1300 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журмын 4.12 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Албан хаагчдын 2023 оны сүүлийн хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, хянаж баталгаажуулах, мэдээлэх чиг үүрэг бүхий Үнэлгээний багийн бүрэлдэхүүнийг хавсралтын дагуу баталсугай.
2. Батлагдсан аргачлалын дагуу албан хаагчийн ажлын гүйцэтгэл, мэргэшлийн түвшинг үнэлэн, 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн дотор 3 дугаар улирлын явцын ярилцлагын нэгтгэл, баталгаажуулсан тайланг үнэлгээний хуудсын хамт Үнэлгээний баг /Б.Байгалмаа/-т ирүүлэхийг хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.
3. Албан хаагчдыг үнэлгээний оноогоор ихээс нь бага руу эрэмбэлэн жагсааж, жагсаалтын эхний 40 хувийг "Маш сайн" үнэлгээний ангилалд, дундах 55 хувийг "Хэвийн" үнэлгээний ангилалд, сүүлийн 5 хувийг "Хангалтгүй" үнэлгээний ангилалд хамруулан тооцсугай.
4. Хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээгээр ажилладаг албан хаагчдыг дээрх жагсаалтад оруулахгүй болохыг дурдсугай.
5. Албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор баталгаажуулж, танилцуулахыг Үнэлгээний баг /Б.Байгалмаа/-т даалгасугай.



ДАРГА

Г.АНХНЫБАЯР

Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын  
даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны  
өдрийн А/10 дугаар тушаалын хавсралт

ATA10154 2830469

АЛБАН ХААГЧДЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ҮНЭЛЭХ, ХЯНАЖ  
БАТАЛГААЖУУЛАХ, МЭДЭЭЛЭХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ  
ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

Б.Байгалмаа  
/Захиргаа удирдлагын хэлтсийн дарга/

Гишүүд:

Н.Пүрэвжаргал  
/Харилцагчийн үйлчилгээний хэлтсийн дарга/  
З.Хонгорзул  
/Архивын хэлтсийн дарга/  
Ш.Наранцацрал  
/Захиргаа удирдлагын хэлтсийн  
ахлах мэргэжилтэн/  
Н.Бат-Ирээдүй  
/Харилцагчийн үйлчилгээний хэлтсийн  
ахлах мэргэжилтэн/  
Э.Батзориг  
/Архивын хэлтсийн ахлах мэргэжилтэн/  
Б.Цэдэн  
/Захиргаа удирдлагын хэлтсийн  
дотоод ажил хариуцсан мэргэжилтэн/

Нарийн бичгийн дарга:

Ш.Сарангэрэл  
/Захиргаа удирдлагын хэлтсийн  
хүний нөөц хариуцсан мэргэжилтэн/